



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2022 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 493

Улаанбаатар хот

Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх  
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, 2020 оны 10 дугаар тогтоолын 8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 6.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын биет бус хөрөнгөд бүртгэлтэй, 171,925,000.00 (нэг зуун далан нэгэн сая есөн зуун хорин таван мянган) төгрөгийн үнэ бүхий 6877 метр квадрат талбай бүхий газар эзэмших эрхээс 118,275,000.00 (нэг зуун арван найман сая хоёр зуун далан таван мянган) төгрөгийн үнэ бүхий 4731 метр квадрат хэсгийг Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч У.Балжинням, Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын дарга Л.Оюун-Эрдэнэ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө данснаас хасах, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ  
132003306

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны ..... дугаар сарын ..... ны өдрийн  
..... дугаар тогтоолын хавсралт

БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД  
БҮРТГЭЛТЭЙ, БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Нэр төрөл	Ашиглалта д орсон огноо	Хэмжих нэгж /м2/	Нэгжийн үнэ (төгрөгөөр)	Нийт үнэ (төгрөгөөр)
1	Газар	2017	2146	25,000.00	53,650,000.00
2	Газар	2014	4731	25,000.00	118,275,000.00
<b>НИЙТ ДҮН</b>			<b>6877</b>	<b>25,000,600</b>	<b>171,925,000.00</b> (нэг зуун далан нэгэн сая есөн зуунхорин таван мянган төгрөг)